



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/130

Бат-Өлзий сум

Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан  
өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, “Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох, мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэл, “Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” аймгийн Засаг даргын 2023 оны А/370 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулах” 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/125 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор сумын хэмжээний зорилтот мал сүргийг бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, дархлаажуулалтад шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар, дархлаажуулалтын ажлын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Бог малын мялзан урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг товлосон хугацаанд хийлгэх зар мэдээллийг малчин, мал бүхий иргэдэд бүрэн хүргэж ажиллахыг (багийн Засаг дарга) нарт үүрэг болгосугай.


4. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын явц, үр дүнд хяналт тавьж, дүнг танилцуулж, холбогдох газар хүргүүлэхийг сумын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (П.Аюушжав)-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

622301268

Сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар  
сарын 23-ны өдрийн захирамжийн *А/130*  
хавсралт



## **ХЯНАЛТЫН БАГ**

Хяналтын багийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)  
Гишүүд: Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
мэргэжилтэн)  
П.Аюушжав (Мэл эмнэлгийн тасгийн дарга)

## **ВАКЦИНЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ**

### **1 дүгээр хэсэг (1,2,6 дугаар баг)**

Ажлын хэсгийн ахлагч: Л.Батчулуун ("Хустын рашаан" мал эмнэлгийн  
үйлчилгээний нэгжийн Малын их эмч)  
Гишүүд: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)  
Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)  
Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)  
Б.Батбилэгт ("Хустын рашаан" мал эмнэлгийн  
үйлчилгээний нэгжийн эзэн)

### **2 дугаар хэсэг (3,4,5 дугаар баг)**

Ажлын хэсгийн ахлагч: П.Содномбалжир ("Хутагт уулын өгөөж" ХХК-ны  
Малын их эмч)  
Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)  
Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)  
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)  
Туслах ажилтан (Арван хоёр иргэн)  
Хөдөө аж ахуйн тасаг

Бат-Өлзий сумын Засаг даргын  
2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн  
А/120 захирамжийн 2 дугаар хавсралт

**БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНИЙ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ  
ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Ажиллах хоног	Удирдах албан тушаалтан	МЭТасаг	Малын эмч	Санитарч, техникч	Туслах ажилтан баригч	Жолооч	Нийт
1	25	4	1	2	2	12	6	13

**ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, БАГАЖ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

№	Зардлын нэр төрөл	Хэмжээ	Шаардлагатай тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ажлын бээлий	ш	75	2000	150000
2	Хурууны лент/нарийн/	Хайрцаг	6	2000	12000
3	Хөдөлмөр хамгаалалын хувцас	ш	10	10000	100000
4	Хурууны лент /бүдүүн/	Хайрцаг	6	5000	30000
5	Хагас автомат	ш	4	100000	400000
6	Автомат шприц	ш	2	195000	390000
7	Ажлын хөлс	12 хүн	7	40000	3.360.000
7	Бусад				100000
	Бүгд:				4.542.000

**ШАТАХУУНЫ ЗАРДАЛ**

№	Төрөл	Туулах км	Шаардагдах шатахууны хэмжээ /л/	Нэг литрийн үнэ	Нийт мөнгөн дүн
1	1-р баг /машин/	500	100	3900	390000
2	2-р баг /машин/	550	110	3900	429000
3	3-р баг /машин/	150	20	3900	78000
4	4-р баг /машин/	450	60	3900	234000
5	5-р баг /машин/	80	10	3900	39000
6	6-р баг /машин/	800	160	3900	624000
7	Мотоциколь /БЗД нар/	2230	28	2640	73920
8	Нөөц түлш		7	2640	18480
9	Хяналтаар явах /машин/	550	110	3900	429000
	Бүгд	5310	601		2315400

---oOo---

Бат-Өлзий сумын Засаг даргын  
2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн  
А/130 захирамжийн 3 дугаар хавсралт

БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	МЭҮНэгжүүдийн нэр	Багууд	Хамрагдах малын тоо төрөл	
			хурга	ишиг
<b>Төлөвлөгөө-35152</b>				
1.	Хустын Рашаан	1-р баг	3067	1068
		2-р баг	4742	2105
		6-р баг	3833	1232
Бүгд			<b>11642</b>	<b>4405</b>
2.	Хутагт-Уулын-Өгөөж	3-р баг	1255	839
		4-р баг	6522	1798
		5-р баг	1391	561
			<b>9168</b>	<b>3198</b>
<b>Нэмэлтээр- 6739 төл</b>				
<b>Аймгийн төлөвлөгөө:</b>			<b>25790</b>	<b>9362</b>
<b>Сумын дүн:</b>			<b>35152</b>	